

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл № 10 (2018 он 3-р сар)

НҮБ дэх дадлага Хөгжлийн бэрхшээлийн салбарын талаарх анхны сэтгэгдлүүд

Дадлага хийх явцад хамгийн их сэтгэл хөдөлгөсөн зүйл нь Хөгжиж буй орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзсан явдал байлаа. НҮБ-ын хуралд улс орнуудын сайд, ерөнхий сайд, элчин сайд гээд төрийн өндөр албан тушаалтнууд оролцдог. Тийм хуралд хөгжиж буй орны Хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцож “Бид халамж, тусламж бус эрхээ эдлэхийг хүсэж байна.”, “Засгийн газар нийгмийн саад бэрхшээлийг арилгахгүй бол нийгэмд оролцох боломжгүй.” гэх мэтээр өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж байгаа нь надад гайхалтай санагдсан. Эхэн үедээ юуны талаар яриад байгааг нь сайн ойлгохгүй байсан боловч аажим аажмаар ойлголттой болж ирсэн юм. Хүрээлэн буй орчин хөгжлийн бэрхшээлийг бий болгоод байна гэсэн ойлголтоос гадна төрийн өндөр албан тушаалтнууд, НҮБ-ын мэргэжилтнүүдэд хандаж өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд надад гүн сэтгэгдэл төрүүлсэн. Тэдний дотор англи хэлэндээ тааруу хүн ч байсан боловч тиймэрхүү зүйлд ач холбогдол өгөлгүйгээр өөрийн санал бодлоо хэлэхийг хүсэж буй хүсэл зориг нь мэдрэгдэж байлаа. Тэр үед би ч гэсэн хэзээ нэгэн цагт НҮБ-ын хуралд өөрийн санаа бодлоо илэрхийлэх юмсан гэсэн бодол төрсөн. Гэвч би тухайн үед Хөгжлийн бэрхшээл гэсэн үгийн “шөо” гэсэн ханзны талаар ч сайн ойлголтгүйгээр дадлага хийж байжээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар эерэг ойлголттой болсон боловч энэ салбарт ажиллана гэж бодоогүй байлаа. Ямар ч байсан аль нэг салбарт мэргэшиж, НҮБ-ын ажилтан болохыг хүсэж байсан юм. Дадлага эхлээд 5 сар өнгөрсний дараа цаашид ямар ажил хийх вэ гэдэг талаар бодож эхэллээ. Яг энэ хэвээрээ НҮБ-д ажиллаж чадахгүй нь, яах вэ... (Үргэлжлэл бий)



DPUB Ахлах зөвлөх Чуба Хусао

МУИС-ийн оюутнууд DET сургалтанд хамрагдлаа (2018.03.26)



Сургагч багш Мэндбаяр оюутнуудтай ярилцаж байна

3-р сарын 21-ний өдөр их сургуулийн оюутнууд DET сургалтанд хамрагдлаа. Энэ удаагийн сургалтыг Мэндбаяр, Лхамжав (хөдөлгөөний бэрхшээлтэй) нар харууцан явуулсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар ярилцах семинарын хичээлээр оюутнууд “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?” гэсэн асуудлын талаар харилцан ярилцлаа. Тус сургалтанд Хууль зүйн сургуулийн 1-р курсын оюутнууд оролцсон бөгөөд “Сургалт оролцоонд тулгуурласан хэлбэрээр явагдсан нь их сонирхолтой байлаа” хэмээн сэтгэгдлээ илэрхийлж байлаа. Семинар удирдсан багш ч гэсэн “Хэрвээ би энэ сэдвээр лекц орсон бол оюутнууд холбогдох хууль эрхзүйн талаар уншиж судлаад л өнгөрөх байсан байх. Оюутнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг өөрчлөсөн үнэхээр ач холбогдолтой хичээл боллоо” хэмээж байсан юм.

Налайх дүүргийнхэн бүх хүнд ээлтэй орчинг бүрдүүлнэ (2018.03.27)

3-р сарын 26-ны өдөр Налайх дүүргийн Засаг даргын Тамгын Газрын албан хаагчид Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдлаа. ХНХЯ-ны үйл ажиллагааны хүрээнд тус сургалтыг Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд зохион байгуулж буй бөгөөд энэ удаагийн сургалт хотын төвөөс алслагдмал Налайх дүүрэгт боллоо. Үндсэн сургагч багшаар Чулуун-Эрдэнэ, Тунгалагтамир (хөдөлгөөний бэрхшээлтэй) нар ажилласан. DET сургалт нь оролцоонд тулгуурласан хэлбэрээр явагддаг ба дасгал ажлын үеэр оролцогчдод туслах багийн чиглүүлэгч, туслах ажилчид гээд 8 хүний бүрэлдэхүүнтэй баг Налайх дүүрэгт очсон юм. Сургалтыг нээж дүүргийн орлогч дарга үг хэлсэн бөгөөд “Энэ жилийн дүүргийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх ажлуудыг тусгасан байгаа. Тухайлбал сонсголын бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд цаас, бал ашигладаг болсон. Мөн жирэмсэн эхчүүдэд дараалал харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлж байна. Өнөөдрийн сургалтаар дамжуулж цаашид холбогдох үйл ажиллагаануудыг улам сайжруулах болно.” хэмээж байсан юм. Дүүргийн албан хаагчид сургалт дуустал маш идэвхтэй оролцсон бөгөөд үйл ажиллагааны жагсаалт боловсруулах үеэр “Үүдний налуу замыг стандартын дагуу засаж янзлах, Хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт өгөх богино хэмжээний уриалга гаргаж аян өрнүүлэх” гэх мэт олон янзын санаа гаргаж байлаа.




“Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?” гэсэн асуудлын талаар харилцан ярилцлаа

JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!



Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1765** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

ШУТИС, Барилга Архитектурын Сургуулийн профессор Гончигбат (2018.03.13)



Гончигбат багш

ШУТИС-ийн Гончигбат багш Монголд дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Монголд 1998 оныг хүртэл барилга байгууламж, замын хүртээмжтэй байдлын талаарх ойлголт огт байгаагүй байна. Тэр үеэс л Гончигбат багш хуульд өөрчлөлт оруулах, стандартыг бий болгох, хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж иржээ. Энэ удаагийн уулзалтаар төслийн цаашдын үйл ажиллагааны талаар зөвлөгөө авсан юм. Гончигбат багш холбогдох стандартуудыг ойлгомжтойгоор тайлбарласан удирдамж, гарын авлагыг боловсруулах, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх ямар шаардлага байгаа тухай хэрэглэгч • ХБИ-ийн дуу хоолой, хэрэгцээг төрийн албан хаагч, хувийн хэвшлийнхэнд уламжлах нь чухал хэмээж байлаа. Мөн “Зөвхөн ХБИ-ийн төлөө бус, бүх хүмүүст ээлтэй нийгмийг бий болгох нь чухал” гэдгийг дахин дахин хэлж байсан юм. Ийм ойлголттойгоор хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж буй багшийн үзэл санаатай төслийн баг ч гэсэн ижил байр суурьтай байна. Цаашид олон ажил дээр Гончигбат багштай хамтран ажиллана гэдэгтээ итгэлтэй байна.

Нагоягийн Их Сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн оюутнуудын хичээл (2018.03.13)



Нагоягийн Их Сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төв (Монгол) дээр зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хичээлд оролцлоо. Тус хичээлд 2-р курсын 16 оюутан хамрагдсан юм. 2-р курсын оюутнууд учраас япон хэлээр сайн ойлгохгүй байж магадгүй шүү гэдгийг танил маань хэлж байсан боловч оюутнууд япон хэлэндээ гайхмаар сайн байсан төдийгүй ямар ч асуудалгүйгээр хичээлд оролцсон. Мөн нэг талархууштай зүйл нь оюутнууд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг урьдчилан судалж илтгэл тавьсан явдал байлаа. Оюутнууд 1) Боловсрол эзэмших эрх 2) Хөдөлмөр эрхлэх эрх 3) Хүртээмж 4) Хөдөө орон нутаг, хот хоорондын ялгаа гэсэн 4 багт хуваагдан тус тусын судалсан сэдвээр илтгэл тавьсан. Мөн Хууль зүйн сургуулийн оюутнууд учраас хөгжлийн бэрхшээлийн асуудлыг “хүний эрх”-ийн үүднээс авч үзэж буй нь гайхалтай санагдсан юм. Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг ихэнх тохиолдолд халамж, эмнэлгийн асуудал гэж авч үзэх хүмүүс олон байдаг боловч эдгээр оюутнуудын хувьд эхнээсээ хүний эрхийн асуудлын үүднээс авч үзэн судалгаа хийсэн байлаа.



Илтгэлийн агуулга нь ч гэсэн маш сайн болсон байлаа!!

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмших эрх байгаа хэдий ч улсын хэмжээнд тусгай боловсролын сургууль ердөө 6 л бий. Түүнчлэн Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд дохионы хэл мэддэггүй багш нар олон байна. Ийм байдлаар тэдний эрх хангагдаж байгаа болов уу? Харааны бэрхшээлтэй иргэд ажилд орох боломж бий юу? Оюутнууд ажилд авна гэсэн зарын дагуу хэд хэдэн компани руу утсаар ярьж үзсэн байна. “Би харааны бэрхшээлтэй хэдий ч энэ ажлыг чин сэтгэлээсээ хийх хүсэлтэй байна. Танай байгууллагат ажилд орох боломжтой юу?” гэсэн тэдний асуултын хариу ямар байсан гэж бодож байна вэ? (←4 компаниас бүгдээс нь татгалзсан хариу авчээ.) 2015 оны байдлаар Улаанбаатар хотод нийтдээ 1798 автобус үйлчилгээнд явж байсан боловч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 1 ч автобус байгаагүй! 2016 онд тэдэнд зориулж 25 ширхэг автобус худалдаж авчээ. Хөдөө орон нутагт ч гэсэн нийгэмд тэгш оролцох эрх бий. Гэвч хөдөө орон нутгийн хувьд сургууль, хүртээмж, хөдөлмөрлөх эрх хангалтгүй байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль ч сайн хэрэгжихгүй байна. Тийм учраас ХБИ-ийн дуу хоолойг сонсонгоо хуулийг хэрэгжүүлэх нэн чухал шаардлагатай! Оюутнууд ХБИ-ийн эрх хангагдахгүй байгаа нөхцөл байдлын талаар

Хуулийн талаарх илтгэл



Оюутнуудтай хамт

өөрсдөө судалж, туршлага хуримтлуулж, шийдвэрлэх арга замын талаар ч гэсэн бодсон байлаа. Илтгэлийн дараа оюутнуудтай санал солилцсон бөгөөд яагаад ХБИ-ийн эрх хангагдахгүй байгаа тухай, мөн Монголын Засгийн Газрын зүгээс Хөгжлийн бэрхшээлийн салбарт хэрэгжүүлж буй бодлого чиглэл, ахиц дэвшил болон ЖАЙКА-ийн төслийн үйл ажиллагааны талаар яриа хийлээ. Энэ удаагийн хичээл үнэхээр шинэлэг болж чадлаа. Оюутнуудын хичээнгүй, идэвхтэй суралцаж буйг хараад би ч бас эрч хүч авсан ба цаашид ийм хичээлийг илүү олон газар зохион байгуулах хэрэгтэй юм байна гэж бодлоо. Монголын их, дээд сургуулийн оюутнууд хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголттой болсноор ирээдүйд бүх хүмүүст ээлтэй, сайхан нийгэм бий болно гэдэгт итгэлтэй байна.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com